



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/144

Мандалговь

Г Аймгийн чадавх бэхжүүлэх баг 7
бүрдүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-ын "б", 29.2 дахь заалт, Сангийн сайдын 2015 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 196 дугаар тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Орон нутагт тэргүүлэх ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх түүнд засаглал болон иргэд, олон нийтийн оролцоог сайжруулахаар аймгийн чадавх бэхжүүлэх багийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Багийн ахлагч: Аймгийн Засаг даргын орлогч
Гишүүдэд: Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга
Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга
Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
Орон нутгийн өмчийн газрын дарга
ХХААГ-ын дарга

Нарийн бичгийн дарга: Орон нутгийн төслийн ажилтан Б.Энхтүвшин
Хоёр. Тогтвортой амьжиргаа-3 төслийн хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг багийн ахлагч /Засаг даргын орлогч Ж.Мөнхчулуун/-д даалгасугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Засаг Даргын 2017 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн А/144 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О. БАТ-ЭРДЭНЭ

0200679